

ДУНДАД УЛСЫН МОНГОЛ СОНИН, СЭТГҮҮЛД ИЛЭРСЭН МОНГОЛОО МАНДУУЛАХ ҮЗЭЛ

Оюун*

* Өвөр Монголын Их Сургуулийн сонин мэдээ, хэвлэлийн ажилтны салбарын эрхлэгч, доктор, профессор

Түлхүүр үг: монгол сурагчид буюу монгол сэхээтнүүдийн эрхэлсэн сонин сэтгүүл, илчлэн шүүмжилсэн нийтлэл, Монголоо мандуулах арга замыг ухуулсан нь

XIII зуунд алдар нэрээ дэлхий дахинд мандуулж, нэг үе сүр хүчин бадран дэлгэрсэн монгол угсаатан Чин улсын (1) хагацуулан салгаж хэсэглэн захирах, ван гүнгийн өргөмжлөл хүртээж илбэн татах, шашин дэлгэрүүлж мунхруулан номхотгох бодлогын 200 гаруй жилийн ноёрхлыг өнгөрөөгөөд XX зуун болж ирэхэд нэгэнт ядуу хоцронгуйн туйлд хүрч, "үхээнц буурай ард угсааны дотор багтсан"¹ байна. Нэн ялангуяа Чин улсын сүүлч үеэс эхэлсэн "иргэдийг нүүлгэн, хилийг бататгах" бодлого ба Бээжингийн засгийн газар болон Нанжингийн засгийн газрын хэрэгжүүлсэн онцгой орон гаргах буюу муж байгуулахаар дамжиж "иргэдийг нүүлгэж, газар тавин атар хагалбарлах, Монгол орны улс төрийн байгууллыг нэгмөсөн муж саяний байгууллаар орлуулж, монголчуудыг улс төрийн талаар, газар орны талаар хэсэглэн салгаж үндэстнийг хайлуу-

лах"² бодлогын үр дүнд "Дотоод Монголын засаг засрал нь харанхуй, эд ашиг нь эвдрэнгүй, утга соёл нь хоцронгүй, ард олны амьдралыг хамгаалахуйяа бэрх, сургал хүмүүжил нь хэлэлцэх газаргүй, зан ааль нь утга гэгээхэн бус"³ болжээ. Иймэрхүү "Очир тамын дор, нимгэн мөсний дээр амьдарч бүхүй гаслантай, түгшүүртэй"⁴ монгол тоотноо дуудан сэрээж, "хэдэн зуун түмэн ард олноо, эрх тэгшийн оронд хүрүүлж, бүрэн ардын засаг засралыг олгуулах"⁵-ын төлөө, Монголын сэхээрсэн залуучууд ба дээд давхаргатай жич давшсан хүмүүс тохиол бүхнийг ашиглан сонин сэтгүүл эрхэлж, үндэстнээ хүчирхэгжүүлэх арга замыг эрэлхийлж, ард угсаагаа мандуулах тухай сурталчлан ухуулсан байна.

Доройтон буураад мөхмөөр болсон үндэстнээ мандуулан хөгжүүлэхэд, юуны урьд сайн арга замыг эрж гаргах хэрэгтэй. Монголоо мандуулах сайн арга замыг олоход өөрийн доройтсон шалтгааныг задлан шинжилж, "өвчинд тааруулж эм тавьбал" сая үндэстнээ тэнхрүүлж чадна гэдгийг тухайн үеийн сэхээрэгсэд гүйцэд таньж байсан юм. Иймээс монгол сурагчид буюу монгол сэхээтнүүдийн эрхэлсэн сонин сэтгүүл

жич бодитой найруулах эрх нь Монголын давшсан хүмүүсийн гарт байсан сонин сэтгүүлүүд, тухайлбал, "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал" (2), "Ирээдүйн Монгол" (3), "Шинэ Монгол" (4), "Манхын хонх" (5), "Дахин мандсан Монголын чимээ" (6), "Хөх туг" (7) зэрэг сонин сэтгүүлүүд цөм үндэстний доройтсон шалтгааныг задлан шинжлэхээс гардан авран мандуулах арга замыг сүвэгчилж, энэ бүхнээ бачим яаралтайгаар монголчууддаа уламжлан ухуулж байсан юм.

Нэг. Монголын доройтсон шалтгааныг эрэлхийлсэн нь

Сэхээрсэн монголчууд үндэстнийхээ доройтон буурсныг Чин улсаас Монголд явуулж байсан бодлогоос шалтгаан эрсэн мөртөө бас Иргэн улсын хоёр үеийн засгийн газрын Монголд авч байсан бодлогоос ч учир шалтгааныг эрж, Чин улсын засгийн газар хүчирхэг Монголыг доройтуулан бууруулсан юм бол Иргэн улсын засгийн газар харин монголчуудыг нэгмөсөн мөхөөх замд оруулсан юм гэж үзсэн байна.

1. Чин улсын Монголыг доройтуулсан бодлогыг илчилсэн байдал

"Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал"-ын "Монголдоо сануулах үг"-д: "Манай Монголын буурай болсон учир нь хэдэн зүйл буй, олон бүгдээр эв найрамдуугүй нь нэг, сургал соёл хүнээс хожигдсон нь хоёр, сүсэг бишрэлд төөрөгдсөн нь гурав... урьд Манж төрийн үед анги бүлэг хуваалдан аймаг угсаагийн санал бодол өгтөхөн болоод, өөр хошууны хүн цагаагчин хэмээн нэрдэн хар хятадыг хүрэхгүйгээр үзэх, нэгэн хошуу

гачигдал чухал дор тохиолдвоос өөр олон хошууд өчүүхэн ч туслахгүй бөгөөд зарим нь хажуугаас ханал болон сууж, эс бөгөөс гал дээр тос дусааж хэргийг ихэдгэх нь даруй монгол хүний нийдэм найрамдуугүйгийн үлгэр болой, сургал соёл хэмээгч ухаан оюуны уг үндэс тул сургалгүй бөгөөс утга оюун нээгдэхгүй, утга оюун нээгдэхгүй бөгөөс ой билиг мунхран баларч, үзэл мэдэл болхи гүехэн болон улс гүрэн тогтнох сөнөх, аймаг угсаагийн мандах буурах, ард олны амар зүдүүр, орон нутгийн түвшин түгшүүрийг огт анхаарахгүй өөр аймгийн хорлох, эзэрхэг улсын дарлах, уул голын өнгө хувирах, эрх ашгийн хасагдахыг огт мэдэхгүй, өдөр бүр амгалан жаргаланг эрж өнгө дарсанд цэнгэлдэхийг эрхэм болгомой...

Манай монгол хүний сүсэглэн бишрэх нь бурхан шашин, гэвч бурханы гол зорилт нь элбэрэн энэрэнгүйгээр үл алахыг эрхэмлэснээс элдэв зүйлийн хэргийг цөм бурхнаа даатгаваас даруй сэтгэлчлэн бүтээж өгмуй хэмээн соёрхсонгүй болой, харин манай монгол хүн буруу сүсгэлж элдэв зүйлийн хэргийг цөм бурхнаа даатган залбирч өөрөө чармайхгүй, ганц амаа ангайн тэнгэрийг харж нэгэн үмх будаа өгмөй хэмээн санаад тариалан төмсийг тарихгүй, тарьснаа таягдан хаяад хамаарахгүй, адуу малаа эээр тавин ажил амьдралаа анхаарахгүй гагцхүү заяаны сайн мууг хэлэлцмөй⁶ гэж Монголын доройтсон шалтгааныг бүлгэмдэл нягтралгүй, утга соёл хоцронгуй, шашин суртахуунд бачлагдсан хэмээн үзжээ.

"Ирээдүйн Монгол"-ын "Монгол угсаатны доройтон муудсаны үнэн

учир"-т: "Бурхан шашин хэмээгч монгол угсаатны дэгжин сайжрах зам дээр хамаг их харшил болмой... Энэхүү үнэн учрыг хянаваас хамгийн их нэр алдаршсан эрхэм нүүрээ монгол угсаатан нь үнэхээр лам суртахууны горыг амссан харгайгаар өдөр ирэхүйеэ доройтон муудах зүг явж байнам... Өдгөө монгол хүний санаа сэтгэлгээний дотор агуулан байх нь мөн хойд төрлийн заяа буянаа хүлээх санаа болой, ийнхүү нэгэнт Чингис хааны үеийн хариуцах эсэргүүцэх цог жавхлантай өчүүхэн төдий ч үгүй болоод мөн бус угсаатны эрх хүчинд захирагдах боол шивэгчин болсон болой. Бас хүнийг төрүүлэх, үхүүлэх эрхийг цөм бурхны

гар дор атгуулж хүн ардын эрхээр болгож үл чадмой хэмээн санаж амой, иймийн тул хатуу зориг амьдрах хүчин, өөрийн бишрэл, хожмын хүсэл эрсийн эрдэмт сахил хүртэл бүрнээр гээгдэж, гагц байх нь доройтон муудсан чадал тэнхээгүй амар жаргах залхуу угсаатан болохуйд хүрсэн болой"⁷ гэж Монголын доройтсон шалтгааныг шашинд мунхарснаас болжээ гэж үзжээ.

"Дахин мандсан Монголын чимээ"-ний "Дурдан сануулах хэдэн үгс"-т: "Манай монгол эв найрамдлаа алдаж элэг сэлэг явсаар, өдгөө дор эл улсаас буурай дорой болсныг хянаваас, манай монгол аймагтан нарууд нэн найрамд-ваас зохимой. Үүнд эс найрамдваас үзэтлээ гангийн ёроолын загас мэт.

Сааргүй зовнил нь нүдний өмнө болжээ... Амар түвшин унтаж бурхан чөтгөр сахиусны зэргийг зүүдэлж байх харанхуй бүдүүлэг монгол ардыг нийтээрээ хашгиран сэрээж жолоодож удирдан, буурай тулгардсан угсаагаа гэгээхэн дөт замаар дагуулан оруулах нь монгол угсааны мохошгүй завшаан тул, хөхүүлэн сэнхрүүлж хүмүүжүүл-бээс нэгэн их чухал үүрэг мөн... Эртнээс өдий бол-тол ирсэн учир шалтгаан нь ма-най Монголын Лигдэн хутагт ха-ны үеэс нааш са-лалцан бутарч ирснээс улам ул-маар утга соёл ух-ран язгуур хотлоо буурсаар дунд ул-сад мөргөгдөж хувь хувьдаа зэрэг эрхмийг өргөмж-

«

*Сэхээрсэн монголчууд
үндэстнийхээ доройтон буурсны
учир шалтгааныг Чин улс, Иргэн
улсаас Монголд авч байсан
бодлогоос эрж, Чин улсын засгийн
газар хүчирхэг Монголыг
доройтуулан бууруулсан бол Иргэн
улсын засгийн газар харин
монголчуудыг нэгмөсөн мөхөөх
замд оруулсан гэж үзсэн байна.*

»

лөгдөн хошуу чуулган хэмээн хуваан өмчилж, хоорондоо хоёр улс мэт, хоёр хошууны ард өшөөтөн адил нэг нь нэгнээ цагаачин гадначин зэргээр хэлэх... Хэдийгээр монгол угсаа нэгэн хэмээн хэлэвч нийгэм найрамдуугаа алдаад нэгэн угсаа болж чадаагүйгээр салхинд савагдсан шар буурцаг мэт сарнисан бутарсан угсаа болсон"⁸ гэж бүлгэмдэл тэмцэл, шашин суртахуун, утга соёлын талаас доройтсон шалт-гаанаа эржээ.

"Дахин мандсан Монголын чимээ"-ний "Манай залуучуудын тушаал үүрэг"-т: "Манай Монгол угаас амар жаргалд тачаарсан ба урагшлан сайжрах явдалд хожимдсон хэдэн зүйлийн сэдвийг ялгаварлан гаргаж

илэрхийлмой. (нэг) Юань улс доройтсоноос нааш Чин улсын үед манай ард иргэдийг хувааж олон газарт суулган улсын гол хүчнийг алдуулсан учир, (хоёр) манай залуус нарыг сургал сурталд явуулахгүй бөгөөд нэн ялангуяа лам хүнийг үлэмж тавьж, нэг үе эм хүүхэд үр ач наргүй болгон хүн амыг цөөрүүлж угсаа аймгийг зөөлөн буурай болгохын уг үндэс нь болжээ, (гурав) манай монголчууд нь мэдлийг нээгдүүлэн ухаанаа нэмэгдүүлэх зүйлийг огт нарийвчлан санахгүйгээр дадсан суртал болгож тус бүрийн нэгэн үеийн амар жаргалыг бодсоор зүтгэн чармайх зориг нь үгүй болоод залхуурах зан нь дадгал болов, (дөрөв) утга соёл юугаа мандуулах онцгой тустай сайн үйлсийг үйлдэхгүй, ноён бологчид нь ямагт өөрийн зэрэг тушаалаа хамгаалан идэх амаа бэхлэхийг санасаар харьяат угсаа олноо доройтуулахад хүргэжээ, (тав) сүм хийдэд суугч их бага лам нар нь, тархин дотроо бурхан шашны нэрийг барин бусад олны эд агуурсныг төлөөсгүйгээр алдуулан авах ба ... жич бас тив ертөнцийг хоосон хэмээх хөндий хоосон үгсийг алдаршуулан олон нийгмийн урагшлах чармайллын урам зоригийг мухруулахаар зохиогоод ... (зургаа) манай монголчууд болгоомжгүйгээр шарын шашны гүн нарийнийг үл ялган нэгэн үзүүрт тэнэг сүсгийн итгэсэн төдийгөөр тэр шашны нэрийг худалдан хуурмагаар мунхруулагчдын үгэнд нэрвэгдээд хожмын сүнс ба хойд төрөлдөө сайн хутаг олсугай хэмээн санаж, өдгөө ертөнцийн аж амьдрахаа хөнгөтгөн, эд хөрөнгөө мэхлэгдсээр, одоо үгээгүй ядуугийн туйлд хүрсэн шалтгаан болжээ"⁹ гэж доройтсон шалтгаанаа зургаан талаас эржээ.

"Хөх туг" сонины "Монгол амьдралыг хөгжүүлж алхан давшиж байх нь"-д: "Монгол хэмээгч, долоон зуун оны урд баруун хоёр тивийг цэргийн баатраар эзэлж ертөнцөд гагцаар байгуулсан их улс болж манджухуй. Ганц монгол угсаатан нь цэргийг хүндэтгэн бичгийг хөнгөлж, тариачин урчууд худалдаачин зэргийн эрдмийг эрхэмлэн шүүмжилсэнгүй бөгөөд, жаргаж амарсаар залхуу дадгалыг олсон дээр нэн өнгөрсөн улс Монголд мунхруулах засгийг хэрэглэн явуулж, Монголыг утга соёлоос гээгдүүлж, нэн Иргэн улсын догшин засгийн үед Монголын амьдралын газар шороог өдрөөс булаан залгаж, эрх сүр үүнээс улмаар буурч нэгэнт үхмээр газарт ирлээ"¹⁰ гэж монгол аймгийн доройтсон нь Чин улсын мунхруулах бодлого ба Иргэн улсын догшин засгаас болсон гэж таньж байсан юм.

Мөн тус сонины "Монгол аймагтан бид нар"-т "Манай монгол аймаг уг нь ариун цагаан тархитан, үнэнхүү шударга журамтан нэгэн явдлыг итгэвээс үхэн үхтлээ үнэн гагцхүү энэ буй хэмээн итгэх тул харгис муу хуурмаг зальхай хятадын арга ухаанд мэхлэгдэн харанхуй мэнэгт төөрөөд буруу замд орсноос нааш хэдэн зуун жилийг зүүднээр өнгөрүүлэн хир заяагаа сахиж бурхан тэнгэрийн авралыг хүлээсээр энд хүрч ирээд"¹¹ гэж буурай дорой болсон шалтгаанаа эржээ. Энд Чин улсыг "өнгөрсөн улс" гэж бөөрөнхийлэн авсан буюу Манж Чингийн засгийн газар ба Иргэн улсын засгийн газрыг нийлүүлээд "харгис, муу, хуурмаг, зальхай хятад" гэж нэрлэсэн нь "Хөх туг" сонин Японы эзэмдэл дэх "Манж улс"-ын (8) харьяанд байснаас юм гэж ойлгох ёстой.

"Хөх туг" сонины "Монгол угсаатны өнгөрснийг нэхэн бодож монгол залуус бид бүгдээр чармайцаагаа хэмээх бодлоо илтгэсэн нь"-д: "Урьд Чингийн үест хүрч ирээд, Монголын ван гүн нарт ... хий хоосон зэрэг өгч тус тусын нутаг хошуунаа суулгаж, газар орныг сахиулснаас бус, манай Монголын утга уянгыг мандуулж, улс төрд хүндэтгэн хэрэглэсэн учир огт үгүйгээр үл барам, харин аль нэгэн сэцэн сэргэлэн бага хүүхдийг нь үлдээж бусдыг нь үсийг огтолж улаан шар дээл өмсгөж, төвд номыг уншуулж, буяны зүг сайн зам бурхан болохын мөрт орвай хэмээн хөхиүлэн лам хүнийг онцгой их хүнд үзэж, хишиг шан ч их бөгөөд хүчин тамирыг нь үл дуусгах хүнд их ажлыг үйлдэхүйд хүн бүр бахарч, хөвгүүнээ лам болгохыг мэдсэнээс бус хорт санааг нь ухсангүй болой"¹² гэж Чин улсын Монголд явуулсан өргөмжлөлийн дүрэм ба шарын шашнаар Монголыг мунхруулж, үндэс угсааг харлуулах ойртсон "хорт санаа"-г илчлэн ухуулжээ.

2. *Иргэн улсын Монгол оронд атар хагалбарлан муж байгуулж "засаг засрал"-ын эрхийг булаасныг шүүмжилсэн нь*

"Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал"-ын "Нэгэн ард угсаатны мөхөж устахын учир хараа"-д: "Түүний устаж сөнөхийн учир хараа нь гурван зүйлийн хөнөөлөөс гарахгүй ... даруй аяндаа улирахын хүчин, засаг засралын хүчин, эд ашгийн хүчин мөн ... манай монгол угсаатан болвоос энэхүү гурван зүйлийн хөнөөлийг давхарлан амсаж буй... Даруй хятад угсаатны энэхүү гурван зүйлээр манай Монголыг хяхан мөлжиж ахуй нь чухам хүнд нь болой.

Дотоодын үхээнц буурай угсаатныг мөнхүү энэ гурван зүйлээр хөнөөн дарлаж, элдвийн уран үгээр олон Монголыг мэхлэн, өөр угсаатныг цөм өөрийн угсаандаа хувилган дагуулж авсугай гэж буй... Энэ нь манай Монголын дотоодоос үүссэн аяндаа улирахын хүчнийг шууд амсаж ахуй хөнөөл болой... Дотоод Монголын эл хошуунаа сянь байгуулж, монгол хүний засаг засралын эрхийг цөм булаан авч, хоосгор хэрэггүй ван гүнгийн цолыг өгч, чухам мэдэл эрхийг цөм сяний гарт оруулж, хятадаа хамгаалан Монголыг дарлаж байхын учир ... энэ нь олон монгол бүгдээрийн нүдээр үзэж, биеэр амсаж байх засаг засралын хүчнээр дарлах хөнөөл биш үү... Манай Монгол угаас үйлдвэрийн хөрөнгө арилжаагийн хөрөнгө, цөм үгүйгийн тул аливаа хэрэгслийн зүйлийг цөм хүнээс эрмэлзэх бөгөөд хулзан хуйхар худалдаачны уран аргад оногдож, ашиг зоосоо учиргүйгээр хонжигдох нь аль олон буй. Монгол газрын эл зүйлийн гаралт нь элбэг. Гэвч олонх эрх хүний гарт орж, өөрөө эзэн болж чадахгүй... Энэ нь эд ашгийн хүчнээр биднийг хөнөөхийн их төлөв болой"¹³ гэж нэг үндэстний устаж мөхөхийн гурван шалтгаан – хувьслын хүчин (шилдэг нь үлдэж, шаар нь орхигдох), улс төрийн хүчин ба аж ахуйн хүчнийг заан гаргаж, энэ гурван талаар цөм хөнөөл амссан монгол үндэстний элэг эмтрэм хувь заяаг тоочжээ.

Тус сэтгүүлийн "Монголын зохистойяа мандуулах явдал хөрөнгө"-д: "Манай монгол угсаатан энэ өдөр болоод, нэгэнт бүдрээд дахин босохуйяа бэрх болжээ. Өдгөө боомтын гадна онд орон суугаад, утга соёл нь мөчид болж, ухаантай

эрдэмтэн ховор болж, эл явдал цөм дэгжихгүй болсон бөгөөд орон газар нь агуу өргөн дээр ам тоо нь өчүүхэн цөөн болсноор өөр угсаатны халдан дурлах сэтгэлийг өдөөн босгож, эл эзэрхэгтэн нарын дарлан мөлжихийн зовлонг амсаж амой. Энэхүү учрыг хэдэн зурвас татлан гаргаж, олноо өргөн сонсгосугай¹⁴ хэмээж, Иргэний засгийн газраас Монгол оронд элдвийн аргаар малын бэлчээрийг хагалж газар нутгийг нь булааснаас монгол хүний амьдрал өдөр ирэхүйеэ хүчир бэрх болсон, цааз хууль тэгшгүй болж, хятад, монголын хэрэг заргад монгол хүн ёс байгаад ёсоо олохгүй, нутаг усаа гүжирлэгдэн булаагдаж, гэр хөрөнгөө алдаж, элгэн садан хагацсан байдал, арилжаа худалдааны дунд хятадын зусар худалдаачинд мэхлэгдэж байх зэргийг дурдаад "одоо удалгүй монгол угсаатан ертөнцөд үлдэхгүй болох магад" гэж эмгэнэжээ.

Мөн тус сэтгүүлд нийтэлсэн "Монгол угсаагаа яахан бататгамай" гэдэгт: "Өдгөө юунд ийм зөөлөн буурай угсаатан болж бусдад дарлагдан байх ажээ. Үүнийг эргэцүүлэн бодвоос нэгэнт эрдэм соёл балрагдаж, уг үндэстний үсэг хэлээ умартсан нь олон болжухуй. Хоёрт эрх хүчнээ алдаж олон ардын санал зориг нь эс нийлмой. Гутгаарт орон нутгаа алдаж аж төрөн амьдрах газаргүй болсноос ийм болжээ. Тиймийн тул өдгөө цагийн хувьсгалд эртхнээ эс урагш давшин монгол угсаагаа мандуулваас бараг амжихгүйд хүржүхүй"¹⁵ гэж үндэстний доройтсоны шалтгааныг утга соёл ба газар нутгаа алдсанаас болсон хэмээн үзэж, хувьсгалын аргаар Монголоо мандуулахыг дурджээ.

"Монгол"-ын "Одоо манай угсааны мөхөхийг шүүмжлэх нь"-д: "Айяа, манай Монголын өнөөх байдал өдөр байсаар улам түгшүүртэй болж, хэцүү дайснууд хэдэн зүгээс шахамдуулан өлсгөлөн чоно адилаар өөр болгон үзэж урж булаалдан идсүгэй хэмээх нь, лав манай хүн ардын тэнэг мунхаг, эрдэм чадлын мөхөс мөчид ба, эд юм байгаад уян сууж оролдохгүй хараагаар тийм зэрлэг сэтгэлийг үүсгэснээ, унар аюул буюу ... монгол нэгэнт өглөөн сүүдэр мэт түгшүүртэй болов. Одоо хэрвээ доорхи хэдэн ангийг нийлүүлэн хэлбээс мөхөх нь зогсоогоор хүлээвээс болмойжаа. Нэг, өөр зуураа эвдрэлцэн цохилдох нь манай аймгийн нэгэнтэйеэ муудсаныг далдлан хэлэх ч хэрэггүй... Хоёр, гадар зовлон улам хэгжүүн болсон нь ... өөр Монголыг муж болгон хувилгаснаа... эдгээр газрын хүн ард өдгөө олонхи нь хайлан шингээгдээд газар шорооны эрхийг нэгэнт автан, бэлчээрлэх амьдралаа бас булаагдахуйд хүржүхүй ... Гурав, хуучин дүрмийг сахисан нь ... манай Монголын цөөн тооны ван гүн эрхтэн нар ... хувьсгал хэмээхийг сонсмогц зориг цөс хэмхрэн залуус хэмээгчийг үзвээс догшин гөрөөснийг учирсан адил, өөрийн тэр хэргэм зэргээ хайрлан хамгаалахуйн тул өөр хүний түүний бошгыг халахаас айн эл шинэ үйлдэх хэрэг бүхнийг аргацаасхан эвдэлмой. Сургууллыг эс үүсгэх ба засаг засалтыг эс шинэтгэх, цэргийн үйлийг эс оролдох зэргээр үүнийг гэрчилж болном"¹⁶ гэж Монголын доройтсон шалтгаан ба түгшүүрт байдлыг өөр зуураа бүлгэмдэлгүй, газар ус нь булаагдсан, хуучнаа баримталж шинэчлэхийг хүсэхгүй гэх мэтийн гурван талаар дүгнэжээ.

"Дахин мандсан Монголын чимээ"-ийн "Монгол засгийн өнгөрөл хийгээд өдгөө ба ирээдүй байдлын өгүүлэл"-д: "Дундад ард улсыг байгуулж таван угсаа хамтаар найралдах учир, төрөл-хөөс чигч шударга монгол хүн нь түүний харгалзан үзэх нь тэгш адил байхаар санаж, чухамхүү халуун үнэнчээр дотогш хандаж өдгөө хүрсэн боловч хэрхэнээ харин амандаа таван угсаа хамт найралдах улс болсон хэмээгдээд тусыг өчүүхэн төдий олж завшсан зүйл огт үгүйгээр үл барам харин Монголын нэгэн угсаатныг гадаад аймаг лугаа адил үзэж газар шороо хийгээд гаралт хөрөнгийг нь түрэмгийлэн эзэлж аливаа эрх хэмжээг нь муж сянь-д оруулж монгол хүний амьдрах замыг таслахуйд хүргэжүхүй"¹⁷ гэж илчлэн Дундад иргэн улсын үе дэх монголчуудын гашуун зовлонт хувь заяаг үнэн зөвөөр олон даяарт таниулахаар чармайж байжээ.

Хоёр. Монголоо мандуулах арга замыг ухуулсан нь

XX зууны 20-40-өөд оны хооронд монгол хүмүүсийн эрхэлж байсан сонин сэтгүүлийг шүүж үзвэл, бүлхэмдэн нягтарч бүлгэм болон бүрэлдэх, утга соёлоо дээшлүүлэн ардын мэдлийг нээх, сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэн үндэстнээ мандуулах мунхаг бишрэлийг арилган лам хуврагийг хязгаарлах, үнэн үйлсийг эрхэмлэж аж ахуйгаа хөгжүүлэх, ард олон нягтран "өөрөө чармайн байгуулах" зэрэг арга замыг дурдан ухуулж, монгол ард олныг үндэстнээ мандуулахыг өөрийн үүрэг болгон урагш чармайн тэмцэхийг уриалсан байна.

Энэ тухай төлөөлөх чанартайгаас хэдийг дурдвал:

1. "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал"-ийн ухуулга

"Монголдоо сануулах үг"-д: "Энэ өдөр монгол угсаагаа дэгжүүлсүгэй хэмээхүл эрхгүй монгол ард бүгдээр хэн альны хязгаар ялгаварыг хаяж энэ тэр хэмээн хуваахгүй, санаагаа нэгтгэн хүчнээ нийлүүлэн зовлон зүдүүрийг хамтатган, үхэх төрөхийг цугаар болгоод олонх сургууль байгуулан олон улсын шинэ сургалыг нээн авчирч монгол бичгээр орчуулан олон ардыг цөм монгол бичиг боловсруулан аймаг угсаагийн бодлыг дэгжүүлэн газар орны засаг засралыг шинэтгэн сайжруулж, үйл заяа хэмээхийг халж, ямбар явдлыг цөм хүний хүчээр бүтээж болмой хэмээн бодож урагш хүчлэн чармайваас аймаг угсаа хэрхэн үл мандах ажээ"¹⁸ гэж Монголоо мандуулахад бүлхэмдэн тэмцэх, сурган хүмүүжлийг эрхэмлэх, засаг засалтаа шинэтгэх хэрэгтэй гэж үзжээ.

"Монголын зохистойёо мандуулах хөрөнгө"-д: "Энэ өдрийн арга нь хатуу зоригоор халан шинэтгэж, хүчин чинээгээр хэвлэн засваас зохимой. Тэрхүү сургал хүмүүжил хэмээх, цэргийн үйл хэмээх, засах засрал хэмээх, сүрэг бэлчээр хэмээх, ажил хөрөнгө хэмээх, ажил амьдарлаг хэмээх, ардын хамгаалал хэмээх хийгээд зан ааль хэмээх зэргийн үйлсийг дэс дараалан үүсгэн эдэж, үнэмшлэн үйлдвээс ... манай монгол угсаатны хожмын буян болж болмой жаа. Сургал хүмүүжил хэмээгч зуун зүйлийн үндэс болох бөгөөд суртал шийдвэр хэмээгч улсыг чийрэг болгохын уг болой... Иймийн тул хурдханаа элбэг ариун сургууль байгуулж, эрдэмтэн оюутныг олонтоо хүмүүжүүлэн гаргаваас зохимой"¹⁹ гэж

дурдаад нийтийн сургал хүмүүжил, ажил хөрөнгийн сургал хүмүүжил, багшийн дүрэмт сургал хүмүүжил, тусгай ангийн сургал хүмүүжлийг хөгжүүлэх арга замыг дурдсан байна.

"Одоо манай угсааны мөхөхийг шүүмжлэх нь"-д: "Айяа! Хүнийг түшин амьдрах нь эцэст үл болмой. Өөрөө чармайн байгуулваас эцэг тэнгэр сая ивээн тэтгэмой. Угсаа аймаг аймшигтай болов. Ард олон боогдолтой болов. Энэхүү үлдэн сөнөх орхицны хооронд өс хавчуулж үл болмой. Олны сэтгэл хот бүтнэ. Уул хадыг нүүлгэж болно. Шив сөхүл, бүх манай аймагтанд хүнд гүнээ эрмэлзэх нь нэгэн сэтгэл эрдмээр харилцан тусалж угсааг хамгаалах, удмыг бататгахаар өөрийн үүрэг болгон урагш чармайн тэмцэлдэн, амьтавьсан Монголын сүнсийг эрлэгийн үүднээс эгүүлэн авчрах ажаамуй. Хэдэн зуун түмэн монгол тоотнууд бүгдээр чармайцгааяа"²⁰ гэж өөртөө биеэ даасан улс төрийг байгуулахыг уриалжээ.

2. "Ирээдүйн Монгол"-ын ухуулга

"Ирээдүйн Монгол"-ын "Монгол угсаатныг дахин мандуулах үгс"-д: "Өдгөө монгол угсаатныг дахин мандуулах үгсийг дор бичье. Нэг, угсаатны ур чадлыг мандуулах учир, гадаадаас ирсэн гашуун зовлонг арилгах арга нь мөн монгол угсаатан өөсөө бүлгэм нийлж, гадар дотрыг хамгаалваас сая чийрэг хүчтэнийг дийлж чадмуй... Үүнээс гадна монгол угсаатны хуучин байсан сайн сайхан ёс эрдмийг бадруулах бөгөөд өөрийн хүчнийг бас батлан дэлгэрүүлмой. Ийм болвоос монгол угсаатан даруй нэгэн бүрэн бүтэн ур чадалтай их угсаатан болж гадаад хүчтэй улс зэвүүрмой. Хоёр, монгол хүний үзэл мэдлийг

бадруулахын учир утга соёл нь нэгэн угсаатны дахин мандахын гол ёс буй... Өдгөө манай монгол хүн бүрийг үсэг таниулж, өдгөөгийн шинэ цагийн мэдэл чадварыг дэлхий дахинд байх эд таваарыг цөмөөр үйлдүүлж чадваас зохимой. Үүнээс бас цэргийн хэрэг явдлыг сургаж хүн ардыг бүлгэмийн замд явуулваас манай монгол хүний үзэл мэдэл даруй бадрахын зүгт зүглэмой. Гурав, орчлонгийн үйлдвэрийг дэлгэрүүлэхийн учир, манай Монголын орчлонгийн үйлдвэр нь ... бэлчээрлэх бөгөөд гөрөөчний явдлыг үйлдмой. Иймийн тул өдгөө бэлчээрлэх ба гөрөөлөх аргыг сайжруулж явуулваас ... монгол угсаатан үүнээс хойш дахин мандахын замд орох болой. Дөрөв, бичиг унших бөгөөд хувьсгалын хэрэг үйлдэх учир ... сэтгэлд хувьсгалын явдлыг бодож Монголыг дахин мандуулах санал байвч мөн нас бага цагт эрдмийг сайн уншиж ухаан санаагаа сайжруулан хүчин тэнхээг тэжээн гүйцэтгэж чадваас, үүний Монголын эрдэмтэн хэмээн нэрийдэж монгол аймгийн нэгэн хувьтны ач тусыг гүйцэтгэн чадмой. Тав, угсаатны тэргүүлэгчийг таниваас зохих учир бидний монгол угсаатан ... угсаатны тэргүүлэгч Дэмчигдонровыг таниваас зохимой. Бид бүгдээр цөм түүний захиаг дагаж өөр өөрийн хүчин чадлаа гүйцэтгэн хэрэг явдлын үйлдвэрийг сайн үйлдвээс монгол угсаатан сая дахин мандахын нэгэн өдөр баймой"²¹ гэж Монголоо мандуулах таван аргыг дурджээ.

“Манай монгол угсаатан өөртөө сэхэн босч ард угсаатнаа мандуулан чармайваас зохих учир"-д: "Өдгөө манай Монголын амин судсан монгол угсаатны төлөө зүтгэлцэн байх олон

эрдэмтэн багш нар өчүүхэн төдийн сэтгэл болгон сануулмуй. (нэг) Засаг засалтыг чанд засан залруулж явуулмой... (хоёр) Хошуу бүрийн нэгэн жилийн доторх эд мөнгөний хэрэгслийг нэгтгэн бодож тогтоомой. (гурав) Эл хошуудын сүм хийд газарт сургууль хөгжөөн байгуулмой ... (дөрөв) Үнэн хөрөнгийг хөгжөөн мандуулмой"²² гэж Монголоо мандуулах дөрвөн зүйлийн бодитой арга дурдаж, эдгээр дөрвөн талын ажлыг биелүүлэхэд монголчууд нэгдэн бүлгэмдэж, нэгэн хүчин, нэгэн зоригоор чармайх бөгөөд гадаадын давшсан соёлыг хүлээн авч, өөрийн үндэстнийхээ хоцронгуй муу, зан суртлыг бүрмөсөн устгаад шинэ амьдрал үзэл, шинэ ёс дүрэм, шинэ утга соёлыг байгуулан хөгжүүлбэл монгол угсаатнаа дахин мандуулж чадна гэж үзсэн байна.

Үүнээс гадна, "Ирээдүйн Монгол"-ын "монгол хүнийг аливаа зүйлийн үйлс хийж сургах"²³, "монгол залуус зүйгээр даруй түргэнээ ард угсаагийн үйлдвэрийг хүчлэн үйлдвээс зохих учир"²⁴, "бид бүгдээр зүтгэж монгол тоотныг мандуулах санаа"²⁵, "сэтгэл санааг нэгтгэх ба засаг заслалтыг нэгтгэх учир"²⁶, "аймшиг ихэдсэн Монгол"²⁷-д монгол угсаатан бүлгэмдэн нягтрах, чармайн зүтгэх, ажил үйлсээ хөгжүүлэх, утга соёлоо бадруулах, сурган хүмүүжлийг хөгжүүлэх, өөсөө засах эрх тэгш болох зэрэг үзэл зорилтоо илтгэжээ.

3. "Дахин мандсан Монголын чимээ"-ний ухуулга

"Дурдан сануулах хэдэн үгс"-д: "Хуучин монголоо монголоор байгуулах бөгөөд харанхуй мунхаг хэмээх хоёр үсгийн дотор, манай монгол хүн нийтийн холбогдолд багтааж бүхий ард

түмнийг сэрээн ухуулан нэгэн хүчин болгож авахуйд адбаши онцгой хүчит утга соёл уран эрдэм ажил хөрөнгөө нээгдүүлэх ухаан мэдэл хатах зорилт хүлцэнгүй даамгай байх хэрэгтэй... Монголын эн тэргүүн Бөртэ чоно хаанаас хааны үндсэн байгуулсан боловч, нэгэнт хувьсан нэгдэж явсаар Чингис хааны биед хүрч ирээд, монгол угсаатан бүхнээ нэгтгэхгүйд юуны зүдэлгүй хэмээсэн ажуу, жич Богд Чингис хаанаас үе улирсаар Тогоонтөмөр хаанд хүрч ирээд хэдүй улсын хэлхээ эвдрэвч, манай монгол угсаа аймаг нь нэгэн ч хувьссангүй, улирсаар Лигдэн хутагт хааны самуун үеэс сая Монголын угсаа аймаг салалцаад энэ үед хүрч иртлээ ийнхүү нэгдэж чадаагүйдээ буурай угсаатны тоонд байнам зээ. Үүний тул энэ ер бус яаралтай цагт тохиолдон учиралдсан олон монгол ах дүү нар танаа мандах алхмын завшааныг олох магад зүтгэлтэй саналаа хүн бүр гүйцэтгэвээс, боловсрохын их шинэ зам мөн"²⁸ гэж түүх язгуураас үүсч задлан шинжилж, Монголоо мандуулахад "адбаши онцгой хүчит утга соёл уран эрдэм ажил хөрөнгөө нээгдүүлэн", "ухаан мэдэл хатуу зорилт" мөртөө "хүлцэнгүй даамгай байх хэрэгтэй" гэж үзжээ.

"Сурган хүмүүжлийн улс гэрт холбогдох нь"-д: "Хянаваас улс гэрийн мандаж буурах нь хүн ардын сайн мууд буй, хүн ардын сайн муу нь ухаан мэдэлд буй, тийнхүү ухаан мэдлийг нээгдүүлж чийрэг сайн болгосугай хэмээвээс эрхбиш сургал хүмүүжилд итгэх хэрэгтэй болой... Үүнд монгол угсаатан 300 жилээс нааш зүйл зүйлийн хорт харанхуй засгийг амссанаар сургал хүмүүжил дэлгэрэхгүй, утга соёл хожимдож, эгнэгтээ үхээнц буурайн

туйл болов"²⁹ гэж сурган хүмүүжлийн чухал чанарыг өгүүлээд, "Монголын холбон нийлэлдэж өөсөө засах засгийн ордон"-ыг байгуулан бүтээсний дараа хошуу бүрт бага сургууль байгуулсан ба томхон хотод дунд сургууль байгуулсан жич шинэ цагийн сургалыг боловсруулсан бөгөөд сурагчийн тоог нэмэгдүүлэхийн хамт Японд сурагч томилон суралцуулж байгааг магтаад "Дахин мандсан монгол угсаатны сургал хүмүүжил түгээмэл болж утга соёл дэлгэрээд чийрэг идэрхэг болгох нь удалгүй биззээ. Тийнхүү олон бүгдээр хүчлэн чармайж зүйл зүйлийн сургуулийг улам элбэг байгуулж сургал хүмүүжлийг үүнээс илүү хөгжүүлж утга соёлыг дэлгэрүүлэх"³⁰-ийг шаарджээ.

Үүнээс гадна, "Дахин мандсан Монголын чимээ"-ний "Монгол залуусын мохошгүй зориг зорилт"³¹, "утга соёлыг бадруулан хөгжүүлэх нь"³², "монгол засгийн өнгөрөлт хийгээд өдгөө ба ирээдүй байдлын өгүүлэл"³³, "утга соёлын мөн чанарын гүехэн өгүүлэл"³⁴, "утга соёлын сэхээрлээс ундралд буян тогтмуй"³⁵, "бүх Монголын сүр жавхлангаа мандуулах"³⁶, "Монголын утга соёлыг бадруулан мандуулахгүй болвоос болохгүйн учир"³⁷, "гэгээхэн андгайгаар ард олноо батлан хамгаалах сэдэв"³⁸ зэрэгт цөм утга соёлоо дээшлүүлж, сурган хүмүүжлийг түгээмэлжүүлж байгаад үндэстнээ мандуулахаар монголчууд хүчлэн тэмцэх хэрэгтэй гэж уриалсан байна.

«
XX зууны 20-40-оод онд
монголчуудын эрхэлж байсан сонин
сэтгүүлийг шүүж үзвэл, сурган
хүмүүжлийг түгээмэлжүүлэх,
мунхаг бишрэлийг арилгах, аж
ахуйгаа хөгжүүлэх зэргээр монгол
ард олныг үндэстнээ мандуулахыг
өөрийн үүрэг болгон урагш чармайн
тэмцэхийг уриалсан байна.
»

4. "Хөх туг" сонины ухуулга
"Сургал хүмүүжүүлэл хийгээд монгол ард угсаа"-д: "Манай Монгол охь манлай тийм их улсыг байгуулаад энэнд яахан ийм буурай болсон буй хэмээвээс, учир олон боловч онцгой нь сургал хүмүүжлийг эс хайхарсан нь буй. Өдгөө бид үүнийг мэдэж ... манай сургал хүмүүжлийг сайжруулан бадруулсугай хэмээвээс түүний угаас суурийг хадаад үүний маш харшил болж ахуй лам нарыг зохистойгоор зохисыг үзэн арилгаж, сургал хүмүүжлийн уг үндэс болох охидын сургал хүмүүжлийг хөхиүлэн явуулж, дараагаар лам болохыг цаазлан зогсоон газар бүр бага сургуулийг улам улам үлэмж байгуулан мэдэлт ард нь хүүхэд ба охидоо сургуулийн танхимд оруулж, нийтээр сургал хүмүүжлийг хүртээн газар бүр түгээмэл явуулан хөхүүлвээс эрхбиш дээш бадарч чадмой хэмээн бодмой"³⁹ гэж сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэх чухал чанарыг дурдаж, сурган хүмүүжлээр Монголоо мандуулах үзлийг ухуулжээ.

"Бидний монгол угсаатны дахин мандахын бишрэлтэй замд чармайлцах чухал шүүмжлэл"-д: "Ядангуй, өвчин, мунхаг энэ гурван асуулт нь манай монгол угсаатанд маш харшил болж амой. Тийнхүү энэ өдөр манай Монгол дахиж мандахын замд урагшлахуйяа, хэрхэвч урдаар энэ хэдэн зүйлийг дайлан сайжруулахгүй

бөгөөс үл болмой... Үүнийг журамлахад доорын мэт хүнд чухал ил бодитойн учир буй. Нэг, гаралт хөрөнгийг хөгжин бадруулахад, тариалан ба тэжээврийн эл зүйлийн ажилд уран аргын хүн эрдэмтнийг тэжээн хүмүүжүүлэх хавсрал ажлыг дээш болгох хэрэгтэй. Хоёр, бие махбодийн хатуу чийрэгт эрүүл хамгааллын бэлтгэл хийгээд байгуулалтыг бүрэн гүйцэтгэх хүн амын тоог үржүүлэх арга. Гурав, утга соёлыг нээгдүүлэхэд утга бичгийн эрдэмтнийг тэжээн хүмүүжүүлэх өдгөөгийн шинжлэл сургалын үйлсийг нягтлан утга зохион орчуулах ба сургуулийг түгээмэл болгохын зэрэг хэдэн зүйл буй⁴⁰ гэж утга соёлоо хөгжүүлж сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэхээр дамжиж үндэстнээ мандуулах арга замыг дурджээ.

Үүнээс гадна, "Хөх туг" сонины "Өөрийн угсаа аймгийн утга үсгээ үл орхихыг чухал болгох нь"⁴¹, "Монгол угсаатны мандах хийгээд мохошгүй хүчлэн шамдах утга соёл"⁴², "Хөгжилтэй урагшлах санал"⁴³, "Өдгөөгийн Монголын байдлыг өгүүлэх нь"⁴⁴, "Утга соёлын тул урагш чармайх монгол залуучуудын зорилт"⁴⁵, "Угсаа аймгийн хөгжин бадрах нь"⁴⁶, "Бидний угсаатан урагш чармайхыг хичээж, угсаа аймгаа сайжруулах нь"⁴⁷, "Монголын сургал хүмүүжүүлэл ба шашин суртахууныг халж хувьсгахыг чухал болгох нь"⁴⁸ зэрэг нийтлэлүүдэд цөм утга соёлоо дээшлүүлж, сурган хүмүүжлийг хөгжүүлэн түгээмэлжүүлэхээр дамжин угсаа үндэстнээ мандуулах үзлийг дурдсан байдаг.

Чин улсын 200 гаруй жилийн үндэстнийг доройтуулах ноёрхол ба Иргэн улсын засгийн газрын үндэстнийг мөхөөх бодлогын харгис дарлалыг

хаширтал амссан монголчууд хагас зууны турш Монголоо мандуулах аль олон арга замыг эрэлхийлэн, хатуужилтай тэмцсээр ирснийг энд тэмдэглэх ёстой.

Ишлэл

¹ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

² Алтандай. 2009. Монголын орчин үеийн түүх судлал. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 71 дэх тал.

³ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

⁴ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

⁵ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

⁶ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

⁷ "Ирээдүйн Монгол", 25 дугаар оны 3 сарын 21 (хуучин улирал), 33 дугаар хугацаа.

⁸ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 737 дугаар оны 1 сарын дэвтэр, 15 дугаар.

⁹ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 6 сарын дэвтэр, 9 дүгээр.

¹⁰ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 8 сарын 30, 24 дүгээр хуудас.

¹¹ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 8 сарын 16, 22 дүгээр хуудас.

¹² "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 6 сарын 14, 13 дүгээр хуудас.

¹³ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

¹⁴ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

¹⁵ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

¹⁶ "Монгол", 1930 оны 5 сарын 25, 6 дугаар хугацаа.

¹⁷ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 10, 11, 12 сарын дэвтэр, 13 дугаар.

¹⁸ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

¹⁹ "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал", 1929.

²⁰ "Монгол", 1930 оны 5 сарын 25, 6 дугаар хугацаа.

²¹ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 24 дүгээр оны 9 сарын 1-ний дармал, 25 дугаар хугацаа.

²² "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 25 дүгээр оны 1 сарын 1-ний дармал, 30 дугаар хугацаа.

²³ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 7 сарын 1-ний дармал, 23, 24 дүгээр хугацаа.

²⁴ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 25 дүгээр оны 2,3 сарын дармал, 31, 32 дугаар хугацаа.

²⁵ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 25 дүгээр оны 2,3 сарын дармал, 31, 32 дугаар хугацаа.

²⁶ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 25 дүгээр оны 2,3 сарын дармал, 31, 32 дугаар хугацаа.

²⁷ "Ирээдүйн Монгол", Дундад ард улсын 25 дүгээр оны 2,3 сарын дармал, 31, 32 дугаар хугацаа.

²⁸ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 737 дугаар оны 1 сарын дэвтэр, 15 дугаар.

²⁹ "Дахин мандсан Монголын чимээ", Монгол утга соёлын хурал дарамлан гаргав. 3 сарын дэвтэр, 6 дугаар.

³⁰ "Дахин мандсан Монголын чимээ", Монгол утга соёлын хурал дарамлан гаргав. 3 сарын дэвтэр, 6 дугаар.

³¹ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 12 сарын дэвтэр, 14 дүгээр.

³² "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 6 сарын дэвтэр, 9 дүгээр.

³³ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 10, 11, 12 сарын дэвтэр, 13 дугаар.

³⁴ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 8 сарын дэвтэр, 11 дүгээр.

³⁵ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 8 сарын дэвтэр, 11 дүгээр.

³⁶ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 8 сарын дэвтэр, 11 дүгээр.

³⁷ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 736 дугаар оны 4 сарын дэвтэр, 7 дугаар.

³⁸ "Дахин мандсан Монголын чимээ", Чингис хааны 737 дугаар оны 1 сарын дэвтэр, 15 дугаар.

³⁹ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 5 дугаар сарын 17, 9 дүгээр хуудас.

⁴⁰ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 6 дугаар сарын 7, 12 дугаар хуудас.

⁴¹ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 5 дугаар сарын 24, 10 дугаар хуудас.

⁴² "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 5 дугаар сарын 31, 11 дүгээр хуудас.

⁴³ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 7 дугаар сарын 12, 17 дугаар хуудас.

⁴⁴ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 7 дугаар сарын 19, 18 дугаар хуудас.

⁴⁵ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 8 дугаар сарын 9, 21 дүгээр хуудас.

⁴⁶ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 8 дугаар сарын 9, 21 дүгээр хуудас.

⁴⁷ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 10 дугаар сарын шинийн 4, 29 дүгээр хуудас.

⁴⁸ "Хөх туг", Энх эрдэмтийн 8 дугаар оны 10 дугаар сарын 11, 30 дугаар хуудас.

Тайлбар

(1) Чин Улс (1636-1911 он): 1634 оны 4 дүгээр сард Зүрчаний Тэнгэрийн Сэцэн хан Дундад улсын Мүгдэн хотонд Их Хуралдай хуралдуулав. Энэ хуралд Монголын Лигдэн хааны хөвгүүн Ээжэй тэргүүтэй Монголын 16 аймаг бүлгийн язгууртнууд жич Манж Хятадын язгууртнууд оролцож Тэнгэрийн Сэцэн ханыг "Богд Сэцэн хаан" хэмээн өргөмжилж, Улсын цолоо Дайчин улс хэмээв. Үүнийг түүхэнд Чин улс гэдэг. Энэ төр Дундад улсыг 1911 он болтол ноёрхсон юм.

(2) "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал": тус дармалыг Бээжинд байх монгол сурагчийн хурлаас 1929 онд монгол, хятад хоёр утгаар хорголжин бараар хэвлэжээ. Тус сэтгүүл "Шүүмжлэл", "Байцаал", "Бага үлгэр", "Шинэ сонсгол", "Тусгай гаргал" гэсэн 5 булантай. Сэтгүүл нь доройтон буурсан монголчуудаа дуудан сэрээж, Монголоо дахин мандуулахаар зорилт болгожээ.

(3) "Ирээдүйн Монгол": тус сэтгүүлийг Нанжин дахь Монгол-Төвдийн сургуулийн монгол сурагч нар 1933 оны намар монгол,

хятад хоёр утгаар хэвлэл эхлүүлжээ. Сэтгүүл нь монгол угсааныхаа ухаан мэдлийг нээж, хөгжүүлэн мандуулах арга ухааныг сүвэгчилсний хамт, утга соёлоор Монголоо мандуулах үзлийг дурдсан байна.

(4) "Шинэ Монгол": тус сэтгүүлийг Няпонд сууж бүхий Монголын хурлаас 1941 оны 9 дүгээр сард монгол хорголжин бараар хэвлэл эхлүүлжээ. Сэтгүүлд "Шүүмжлэл өгүүлэл", "Судар шастир", "Газрын зүй", "Ерийн мэдэл", "Хүүхдийн уншлага" гэх байнгын булантай. Сэтгүүл нь Японы шинэ соёлыг Монголд удирдан оруулж, Монголын эрдэм соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэхэд зорилт болгожээ.

(5) "Манхын хонх": тус сэтгүүлийг Няпонд сууж бүхий монголчуудын хурлаас 1935 оны 4 дүгээр сард монгол, хятад утгаар Японод хэвлэжээ. Сэтгүүл нь эрдэм сургалаа бадруулж, ухаан мэдлээ нээгдүүлэн, утга соёлоо хөгжүүлж, бусад ард угсаатантай дан сацуу болгохыг зорьжээ.

(6) "Дахин мандсан Монголын чимээ": тус сэтгүүлийг "Монголын утга соёлын хурлаас" 1940 оны 10 дугаар сард тосон дармалан хэвлэл эхлүүлжээ. Уул сэтгүүл утга соёлыг дэлгэрүүлэх, "Монголыг хязгаарын засаг"-т засаг заслалд тус нөхвөр болох, дахин мандсан Монголын хэрэгт тус болох ба ард олны ухаан мэдлийг нээгдүүлэхээр зорилт ба үүрэг болгосон байдаг.

(7) "Хөх туг": тус сониныг "Хөх туг" сэтгүүлийн хоршооноос 1941 оны 1 дүгээр сарын 6-нд Чанчун хотод хорголжин монгол үсгээр хэвлэл эхлүүлжээ. Уул сонин тухайн цаг үеийн дотоод, гадаадын чухал явдлыг өргөн хэмжээгээр тусгахын хамт Японы "Зүүн Азийн шинэ ёс дүрмийг байгуулах" гэдгийг ихэд сурталчилдаг байв. Дагууд нь монголчууддаа зориулан мал аж ахуйгаа хэрхэн хамгаалах ба хөгжүүлэх, эрүүл хамгаалал, ариун цэврийг эрхэмлэх суртлыг бий болгох, гэр

бүлийн амьдрал ахуйгаа өөд татах тухай аль олон мэдлэг буюу санууламж дурджээ. Тэрчлэн шинжлэх ухаан ба түүх соёлын талын мэдлэг мэдэцийг уламжилж, утга зохиол, уран зургаар монголчуудаа соён хүмүүжүүлж байв.

(8) "Манж улс": 1932 оны 3 дугаар сарын 1-нд Японы цэргийн талын тохируулгаар "Манж улс"-ын засгийн газар Чанчун хотод байгуулагдав. Улсын нутаг дэвсгэр нь Мүгдэн, Гэрэн, Хар мөрөн, Халуун гол зэрэг дөрвөн муж ба Жирэм, Зуу-Уд, Зост зэрэг гурван чуулган хийгээд Хөлөн буйрыг багтааж, Улсын тэргүүн Пү И-г "засаг баригч" хэмээгч гэж, оны цолыг "ихдээ нийтлэгч" хэмээн тогтоожээ. 1934 оны 3 дугаар сарын 9-нд "Манж улс" хаант байгууллыг хэрэгжүүлж Пү И хаан сууж, оны цолоо "Энх эрдэмт" хэмээв. Үүнийг Хятадын түүхэнд "Манж улс" хэмээдэг. 1945 оны 8 дугаар сард Японыг эсэргүүцэх дайн ялалт олсноос тус хуурмаг засаг арилсан байна.

Резюме

В статье автор рассматривает историческое влияние, которое оказали монгольские газеты "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дармал" ("Издание, выпускаемое собранием монгольских учащихся в Бейпине"), "Ирээдүйн Монгол" ("Будущая Монголия"), "Шинэ Монгол" ("Новая Монголия"), "Манхын хонх" ("Манхинский колокол"), "Дахин мандсан Монголын чимээ" ("Известия о возродившейся Монголии"), "Хөх туг" ("Синее знамя"). Издатели этих газет и журналов ставили целью выявление причин, приведших к упадку некогда великой Монголии, и подвергали серьезному анализу скорбное состояние страны, попавшей под иносземный гнёт. На страницах этих изданий авторы выдвигали различные версии относительно возрождения былого величия Монголии.